

САНХҮҮ, АР ТАЛЫН АЛБАНЫ САНХҮҮГИЙН ХЭЛТСЭЭС
2026 ОНЫ ЭХНИЙ 8 САРЫН БАЙДЛААР ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

2026 оны 09 дүгээр сарын 25

Улаанбаатар хот

Санхүү, ар талын албаны Санхүүгийн хэлтсээс 2026 онд 13 анги, байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаа болон Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудын хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалтын хуваарийг энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдөр батлуулж, энэ оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 19в/1125 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагад хүргүүлсэн.

Батлагдсан дотоод хяналт шалгалтын хуваарийн дагуу Булган, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн цагдаагийн газар, Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Экологийн цагдаагийн алба, Сүлд чуулгад хяналт шалгалт хийх удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргаар батлуулан, хуваарь төлөвлөгөөний санхүүгийн бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан.

Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийн засаж залруулах зөвлөмжийг хамрагдсан алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаа.

САНХҮҮ, АР ТАЛЫН АЛБА